



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/220

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 15 дугаар зүйлийн 15.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” 2024 оны 02 дугаар сарын 15-ний А/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн А/161 дүгээр “Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн 1 дүгээр хавсралтад Хөвсгөл аймгийн нэр бүхий сумдад бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлыг хэсэгт Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар, Хөвсгөл аймгийн Зоонозын өвчин судлалын төв, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрыг нэмж өөрчлөлт оруулсугай.


2. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг технологийн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг улс, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр тусад нь гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын Газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

671010697